

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн  
2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн  
12 дугаар тогтоолын хавсралт



## НҮҮР АМ СУДЛАЛ

Нүүр амны гажиг засал судлал, Нүүр амны мэс засал судлал, Нүүр амны согог засал судлал, Хүүхдийн нүүр ам судлал, Шүдний ерөнхий эмчилгээ судлалын чиглэлээр мэргэшлийн зэрэг горилогчид дараах тусгай шаардлагыг мөрдөнө.

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Мэргэшлийн тусламж үйлчилгээний шинэ арга, техник эзэмшсэн байх эсхүл ажлын байранд шинэчлэн хийсэн бодит дэвшилтэд ажлыг зургаар баталгаажуулсан байх /дотоод болон гадаадын мэргэжлийн сургалтад хамрагдсан гэрчилгээ болон хөтөлбөрийн хуулбараар баталгаажуулах /;
2. Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах, үзлэгт хамруулсан байх /урьдчилан сэргийлэх үзлэгийн тайлан, зургийн хамт хавсаргах/;
3. Мэргэшлийн чиглэлийн эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцсон байх;
4. Сургалт эрхлэх байгууллагаас /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ мэргэжил, мэргэшлийн чиглэлээр зохион байгуулсан төгсөлтийн дараах тасралтгүй /мэргэжил дээшлүүлэх эсхүл багц цаг/-ийн сургалтад хамрагдсан байх;
5. Халдвар хамгааллын чиглэлээр мэргэжлийн байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагаанд оролцсон байх.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Мэргэшлийн чиглэлээр судалгаа хийн олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлсэн байх эсвэл эрдэм шинжилгээ судалгааны хураангуйг гадаад болон дотоодын мэргэшлийн чиглэлийн хэвлэлд нийтлүүлсэн байх;
2. Мэргэжлийн чиглэлийн зөвлөгөө, шинжлэх ухаан, танин мэдэхүйн нийтлэл, шинэ мэдээ, мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр иргэдэд хүргэсэн байх;
3. Сургууль, цэцэрлэгийн насны хүүхэд, өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй/ иргэдийн дунд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах, үзлэгт хамруулсан байх /1200-аас доошгүй, урьдчилан сэргийлэх үзлэгийн тайлан, зургийн хамт хавсаргах/ ;

4. Сургалт эрхлэх байгууллагаас /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ мэргэжил, мэргэшлийн чиглэлээр зохион байгуулсан төгсөлтийн дараах тасралтгүй /мэргэжил дээшлүүлэх эсхүл багц цаг/-ийн сургалтад хамрагдсан байх;
5. Халдвар хамгааллын чиглэлээр мэргэжлийн байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагаанд оролцсон байх.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Мэргэшлийн тусламж үйлчилгээнд шинэ арга, технологи нэвтрүүлсэн байх эсхүл докторын зэрэг хамгаалсан бүтээл байх /оюуны өмчийн гэрчилгээтэй байх, / Мэргэшлийн чиглэлээр 3-аас доошгүй судалгаа хийж дотоодын болон олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлсэн байх;
2. Мэргэшлийн чиглэлээр олон улсын сургалтад 10-аас доошгүй удаа хамрагдсан байх;
3. Горилж буй мэргэшлийн чиглэлээр гарын авлага, ном хэвлүүлсэн байх;
4. Горилж буй мэргэшлийн чиглэлээр салбарын хэмжээнд үзүүлсэн тусламж үйлчилгээний тайланг хавсаргах;
5. Салбарын хэмжээнд баримталж буй мэргэжил арга зүйн чиглэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад оролцсон байх;
6. Горилж буй мэргэшлийн чиглэлээр сургалт эрхлэгч байгууллагаас зохион байгуулсан төгсөлтийн дараах тасралтгүй сургалт /мэргэжил дээшлүүлэх эсхүл багц цагийн сургалт/ удирдсан байх;
7. Халдвар хамгааллын чиглэлээр мэргэжлийн байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагаанд оролцсон байх.